

ICANAS-38 ДУГААР ОЛОН УЛСЫН ХУРАЛ БНТУ-Д БОЛЖ ӨНДӨРЛӨВ

Бүгд найрамдах Турк Улсын нийслэл Анкара хотноо Ази, Хойт Африк судлалын олон улсын 38 дахь их хурал 2007 оны 9-р сарын 10-15 хооронд чуулав. Тус их хуралд БНСАУ, Энэтхэг, Япон, Малайз, Монгол, БНХАУ, АНУ, ОХУ, ХБНГУ, Болгар, Франц, Гүрж, Израйл, Туркмен, Татарстан, Киргиз, Беларусь, Иордан, Украин, Эстон Молдав, Израиль зэрэг дэлхийн 60-аад орны 1800-аад эрдэмтэн судлаач оролцон чуулав. Уг хурал нь

1. Хэл шинжлэл, хэл зүй, хэлний боловсрол
2. Түүх, соёл иргэншлийн түүх
3. Шашин судлал
4. Гүн ухаан
5. Эдийн соёл
6. Дорно дахины судлал
7. Хүрээлэн буй орчин болон хотжилтын асуудал, шийдэл
8. Соёлын өөрчлөлт, хөгжил, хөдөлгөөн
9. Эдийн засаг
10. Олон улсын харилцаа
11. Уран зохиол судлалын асуудал, шийдэл
12. Музей, архив, номын сан, хэвлэгчид ба зохиогчийн эрх
13. Хөгжмийн соёл ба хөгжмийн боловсрол зэрэг салбараар чуулсан болно.

Тус их хуралд манай улсаас академич Т.Дорж “Монголын эзэнт гүрний хаан Чингисийн удирдахуйн аргын зарим онцлог”, академич Д.Цэрэнсодном “Монгол, Туркийн уран зохиолын эртний дурсгал дахь яруу найргийн нэр томъёоны уялдаа холбоо”, профессор О.Адъяа “Даяаршил ба Монгол Улсын хэлний бодлого”, академич Б.Энхтүвшин “Монголын нүүдэлчдийн төрийн уламжлал”, профессор Д.Цэдэв “Монгол, Туркийн уран зохиолын харилцааны арга зүйн асуудалд” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлжээ.

*Мэдээ бэлтгэсэн Б.Мандхай (ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан)*